




11th Story

Лазарыг амилуулав!

Lazarus

Лазарыг амилуулав!

– 11st Story –



- Өгүүлэгч** Лазар ... гэдэг хүн байв. Лазар хоёр эмэгтэй дүүтэй. Тэднийг нь Мариа, Марта гэдэг. Есүс гурвууланг нь ихэд хайрладаг байсан ба тэдэнтэй хамт цагийг хөгжилтэй өнгөрөөдөг байжээ. Нэгэн өдөр Есүс шавь нартайгаа хамт байх үедээ Лазарыг өвдсөн тухай сонсов.
- Есүс** Лазар өвдсөн гэнэ. Тэднийх рүү очиход хоёр өдөр зарцуулдаг. Лазар унтаж байгаа учраас Би очоод түүнийг сэрээе.
- Томас** Гэхдээ Эзэн минь, унтсан юм бол өөрөө сэрэхэд болох биш үү?
- Шавь нар** Харин тийм.
- Есүс** Шавь нар минь, Би 'Лазар унтаж байна' гэж хэлсэн жинхэнэ утга нь үнэндээ Лазар үхсэн гэсэн утгатай.
- Шавь нар** Юу ? аан ...
- Өгүүлэгч** Есүс болон шавь нар нь Лазарын амьдардаг тосгонд хүрч ирлээ. Очоод хартал Лазар хэдийнээ үхчихсэн, булшинд ороод 4 өдөр болсон байв. Марта Есүсийг ирсэн гэж сонсоод гадагш гүйн гарч ирээд Түүнийг угтан авав.
- Марта** Миний Эзэн, хэрэв Та энд байсан бол ах минь үхэхгүй байх байсан юм. Гэхдээ одоо ч болов Эзэн та юуг ч гэсэн Бурханаас гуйвал Бурхан өгнө гэдгийг би мэдэж байна.
- Есүс** Марта, чиний ах Лазар дахин амилна.
- Марта** Тийм ээ, эцсийн өдөр, дахин амилалтын өдөр ах минь дахин амилна гэдгийг би мэдэж байна.
- Есүс** Би бол амилал бөгөөд амь мөн. Надад итгэдэг хүн үхсэн ч амьдрах бөгөөд амьд байхдаа надад итгэсэн хүн мөнхөд үхэхгүй. Марта, чи үүнд итгэдэг үү?
- Марта** Тиймээ, Эзэн минь, Эзэн бол Христ, ертөнцөд ирсэн Бурханы Хүү гэдэгт би итгэдэг.
- Мариа** Өө Эзэн минь, Та энд байсан бол миний ах үхэхгүй байх байсан.
- Өгүүлэгч** Есүс Мариа, Марта болон хамт дагаж ирсэн хүмүүс гуниглан уйлахыг хараад сэтгэл нь ихэд өвдөв. Есүс Лазарыг хаана тавьсаныг асуулаа.



Есүс	Лазар хаана байна вэ?
Марта	Эзэн минь, ийшээ явна уу
Өгүүлэгч	Бүгд хамтдаа Лазарын булшинд хүрч очих үед Есүс Мариа, Марта болон хамт буй хүмүүст булшны урдах чулууг зайлуул гэж айлдав.
Марта	Эзэн минь, ах минь булшинд оршуулагдаад хэдийнээ 4 өдөр өнгөрсөн болохоор үнэр ихтэй байгаа.
Есүс	Марта, чи итгэж байвал Бурханы сүр жавхланг харах болно гэж Би чамд хэлээгүй гэж үү? Хурдан тэр чулууг холдуул.
Шавь нар, Марта, Мариа	Эцэг минь, үргэлж залбирлыг минь сонсдогт баярлалаа. Тэгсэн ч ийм үгийг хэлж байгаа нь тойрон зогссон хүмүүсийн төлөө юм. Тэдэнд Эцэг Таныг Намайг илгээсэн гэдэгт итгүүлэхийн тулд юм. За бэлэн болсон уу?
Есүс	Тиймээ!!
Есүс	Лазар аа! Босоорой!
Өгүүлэгч	Лазар үхсэн байсан. Есүс булшинд ирэх үед тэр хэдийнээ 4 өдөр тэнд байсан. Есүс булш руу алхаж очоод Эзэний эрх мэдлээр Лазарын нэрийг дуудахад, Лазар алхаад гарч ирсэн. Гар хөл нь даавуунд ороолттой, нүүр нь алчуураар боолттой байв. Харин Лазар булшнаас амилаад өөрийнхөө хөлөөр алхаж гарч ирсэн юм!
Шавь нар, Марта, Мариа	Хөөх! Янзтай! Гайхалтай ! Юу болох нь энэ вэ~~
Есүс	Түүнийг тайлж алхуулагтун.
Лазар	Миний Эзэн, Есүс!
Есүс	Сайн уу Лазар аа!
Лазар	Мариа! Марта!
Марта, Мариа	Ах аа, Лазар ахаа ! баярлалаа, Миний Эзэн! Есүс минь баярлалаа!
Өгүүлэгч	Энэ гайхамшгийг хоёр нүдээрээ харсан шавь нар нь ихэд гайхацгаасан бөгөөд Есүс бол Бурханы Хүү, Христ мөн гэдэгт чин сэтгэлээсээ итгэв. Мариа, Марта нартай хамт байсан хүмүүс бас тэр үеэс хойш Есүст итгэсэн юм. Бас хэд хэдэн хүн фарисайчууд дээр очоод Есүсийн хийсэн зүйлийг мэдэгджээ.
Фарисай 1	Есүсийн үйлдсэн гайхамшгийг сонссон фарисайчууд Есүсээс болж ихэд уурлав. Тэргүүн тахилчид болон фарисайчууд зөвлөлд цуглаж хуралдав.
Фарисай 2	Есүсийг учрыг нь олох хэрэгтэй! Одоо түүний хийсэн зүйлийг сонсохоос залхаж байна.
Фарисай 2	Би түүнийг 5000 гаруй хүнийг хооллосон гэж сонссон.



- Фарисай 3** Би түүнийг усан дээгүүр алхсан гэж сонссон.
- Фарисай 4** Би түүнийг муу ёрын сүнсийг зэмлэн зайлуулсан гэж сонссон.
- Фарисай 1** Тэр өвчтэй хүнийг эдгээж, үхсэн хүнийг амилуулж, сохор хүнийг хараатай болгож, сонсож чадахгүй хүнийг сонсдог болгосон гэж бүгд түүнд сайн байна. Түүнийг энэ хэвээр нь зүгээр орхивол бүгд түүнд итгэнэ.
- Фарисай 3** Тэгэх юм бол Ромчууд хүртэл хуйлран ирэх болно!
- Фарисай 4** Тэгвэл Ромчууд энэ улсыг мөхөөнө!
- Өгүүлэгч** Фарисайчууд Есүсээс болж уурлах хооронд тэдний дундаас нэг нь босч хэлэв. Тэр нь тэргүүн тахилч Каиаф байв.
- Каиаф** Үгүй ээ! Та нарт мэдэх юм гэж алга. Бид юу хийх ёстойгоо мэдэхгүй байна? Бүх үндэстэн мөхөхгүйн тулд ард түмний төлөө нэг хүн үхэх нь дээр гэдгийг та нар бодолцохгүй байна.
- Фарисайчууд** өө, тийм! Сайхан санаа байна аргагүй л !
- Өгүүлэгч** Тэр өдрөөс хойш фарисайчууд Есүсийг алах төлөвлөгөө зохиож эхэлсэн юм.